



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 216

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар дахин худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, сэргээн засварлах боломжгүй болсон хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй 53,976,190.00 (тавин гурван сая есөн зуун далан зургаан мянга нэг зуун ерэн) төгрөгийн балансын үнэ, 27,005,622.00 (хорин долоон сая таван мянга зургаан зуун хорин хоёр) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг дахин нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг шинэчлэн тогтоосугай.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын ерөнхий захирал О.Доржсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001775

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
өдрийн **2/6** дугаар тогтоолын
хавсралт

Олон улсын хуухдийн Нийрамдал цогцолборын
үндсэн хөрөнгөд бүртэлтэй нээлттэй дуудлагын
худалдаагаар дахин худалдах автомашин жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арагл	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ЫН 2017 оны 576 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1	Sinotruk Hovo, 41-95 УБВ, арал №LZZAELMD 47C011743	48000 2007/ 2007	35,000,000.00 20,416,667.00	14,583,333.00 14,600,000.00	7,300,000.00 7,300,000.00	1,825,000.00 1,825,000.00	
2	Mitsubishi canter, 86-97 УБК, арагл №FE51CB551 356	49200 1999/ 2010	18,976,190.00 6,588,955.00	12,387,235.00 12,400,000.00	6,200,000.00 6,200,000.00	1,550,000.00 1,550,000.00	
			53,976,190.00 (тавин түрван сая ёсөн зүүн далан турган мянга нэг зүүн хорин хоёр) Нийт дүн	27,005,622.00 (хорин доллоон сая таван мянга турган зүүн мянга нэг зүүн хорин хоёр) Найман	26,970,568.00 (хорин зургаан сая ёсөн зүүн далан мянга таван зүүн жаран найман)	13,500,000.0 0 (арван гурван сая таван зүүн мянган)	